

Эрүүл мэндийн төвийн даргын 2025 оны 4 сарын 25 ны
А/10 дугаар тушаалын гуравдугаар хавсралт

ЯАРАЛТАЙ ШИНЖИЛГЭЭ БОЛОН ШИНЖИЛГЭЭНИЙ АЮУЛГҮЙ
ХАРИУГ БҮРТГЭХ, МЭДЭЭЛЭХ БАТАЛГААЖУУЛАХ,
ҮЙЛ ЯВЦЫГ ТОДОРХОЙЛОХ ЖУРАМ

1. Нийтлэг үндэслэл: Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, өөрчлөлтэй шинжилгээнд эмч хугацаа алдалгүй дүн шинжилгээ хийхэд оршино.

2. Үйл ажиллагаа :

2.1 Эмчийн төлөвлөсөн шинжилгээг стандартын дагуу үнэн зөв авч, шинжилгээг хийх ба сорьцыг зөв хадгалж тээвэрлэх

2.2. Шинжилгээний сорьцыг цуглуулах, хүлээлгэн өгөх, хариуг илгээх, үйл ажиллагааг эрүүл мэндийн төв хариуцна.

2.3. Шинжилгээнд хамрагдах гэж байгаа үйлчлүүлэгчийг шинжилгээ өгөхөд бэлтгэж мэдээлэл өгч, бэлтгэлийг нь хангуулсан байна.

2.4 Шинжилгээний хариу өөрчлөлт ихтэй яаралтай эмчилгээ эхлэх шаардлагатай тохиолдолд эмчлэгч эмчид яаралтай мэдэгдэнэ.

2.5 Шинжилгээний хариуг лаборант тухайн илгээсэн эмчид утсаар болон бичгээр илгээнэ.

2.6 Лаборант шинжилгээний аппаратуудыг гадаад болон дотоод хяналтыг хийж баталгаажуулсан байх

2.7 Тухайн шинжилгээнүүдийг эмчлэгч эмч эмнэлгийн үйлчлүүлэгчид хүлээлгэн өгч, хувь хүний нууцыг чандлан хадгална.

2.8 Яаралтай шинжилгээ хийх шаардлагатай үед хариуцсан мэргэжилтэн болон холбогдох хүмүүсийн утас нээлттэй дуудагдан ажиллахад бэлэн байна.

2.9 Шинжилгээ бүрэн хийгдэж шинжилгээний хуудсанд хариу хэвлэгдсэн үед нь лаборант болон тухайн илгээсэн эмч баталгаажуулсан байна.

2.10 Шинжилгээнд үндэслэн оношилгоог үнэн зөв хийж, эмчилгээ үйлчилгээг түргэн шуурхай стандартын дагуу эмчилгээ үйлчилгээг үзүүлнэ.

.....ОоО.....

ЛАБОРАТОРИД МӨРДӨГДӨХ АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ

1. Тус лабораторид эмнэлгийн лабораторийн аюулгүй ажиллагааны нийтлэг дотоод журмыг баримтална.

2. Хориглох зүйлс

- Лабораторид тамхи татах, ууж идэх хүнсний зүйл хадгалах гоо сайхны зүйлс хэрэглэхийг хориглоно.
- Соруулыг амаараа сорж болохгүй
- Лабораторид гадны хүн орохыг хориглоно. Лабораторид зөвхөн төлөвлөгөөт ажлаа гүйцэтгэгч ажилтан орох эрхтэй.

3. Заавал мөрдөх зүйлс:


- Лабораторид ажиллахдаа /сорьц авах, шинжилгээний ажилбар хийх угаалга ариутгал хийх гэх мэт/ заавал бээлий өмсөнө.
 - Лабораторид эмх цэгцтэй цэвэрч байдлыг эрхэмлэж зөвхөн шинжилгээ хийхэд шаардлагатай зүйлийг байрлуулна.
 - Лабораторийн ажилтан бүр лабораториос гарч явахын өмнө хувцсаа сольж гараа угаана.
 - Бохирлогдсон дахин хэрэглэх зүйлийг заавал ариутгана.
 - ЭМС-ын тушаал заавруудыг мөрдөж ажиллана.
 - Лабораторид ажиллах хүн бүр малгай халат, өмссөн байна.
 - Ажил эхлэхийн өмнө дууссаны дараа ажлын ширээг халдваргүйжүүлэх уусмалаар арчих
 - Аппарат тоног төхөөрөмж багаж хэрэгсэлтэй болгоомжтой ажиллах ажил дуусмагц цахилгаанаа салгах
 - Аппарат тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааны зааварчилгааг мөрдөж ажиллах
 - Шинжилгээ хийж байгаа үедээ гадны хүнтэй ярих болон утсаар ярихыг хориглоно.
4. Халдвартай материалтай химийн физикийн хөнөөл бүхий бодис ууршихаас болгоомжлох
- Хүчтэй хүчил шүлт найруулахдаа хамгаалах хувцсаа өмсөж болгоомжтой ажиллах эхлээд усаа хийж, дараа нь концентрацтай хүчил шүлт хийж найруулна.
 - Хүчлийг содын уусмалаар шүлтийг сулруулсан хүчлээр саармагжуулна.
5. Лабораторид гарсан осол гэмтлийг гарах бүрд бүртгэх арга хэмжээ авч дахин гарахаас сэргийлэх
6. Лабораторид ажиллахад аюулгүй ажиллах талаар байнгын сургалтад хамруулна. Шинээр ирсэн ажилтанд нэг бүрчлэн зааварчилгаа өгнө.
7. Аюулгүй ажиллагааны журмыг мөрдөж буй байдалд тасгийн эрхлэгч хяналт тавина.

**Яаралтай шинжилгээ болон аюулгүй хариуг бүртгэх, мэдээлэх
баталгаажуулах, үйл явцыг тодорхойлсон зураглал**


2023 он

Бүрд


**ЛАБОРАНТ ШИНЖИЛГЭЭГ АВЧ
НОЦТОЙ ӨӨРЧЛӨЛТТЭЙ ХАРИУГ**



ЭМЧЛЭХ ЭМЧИД МЭДЭЭЛЭХ



**ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГАД МЭДЭЭЛЭХ**



**АЙМАГ РУУ ХОЛБОГДОХ МЭРГЭЖЛИЙН ЭМЧЭЭС
ЗӨВЛӨГӨӨ АВЧ ХАРИУ ХЭМЖЭЭ АВЧ АЖИЛЛАНА**

ЭМНЭЛ ЗҮЙ ЛАБОРАТОРИЙН СТАНДАРТ

2025 оны 01 дүгээр сарын 05

Бүрд

№	Стандарт үзүүлэлтүүд	Хийгдэх ажил
1	ЭМТХ-ийн 20.2.1 Эмнэлгүүдийн бүтэц үйл ажиллагааны стандарт MIS 5095 стандартын 8,4,2 MNS 6188, 2010 стандартын 6.5.1.1.5.1.4	Лабораторийн хэсэг клиник гематологи биохими, шээсний ерөнхий шинжилгээ иммунологи шинжилгээг стандартын дагуу хийдэг.
2	ЭМТХ-ийн 20.2.1 Эрүүл мэндийн лабораторийн чанар ба чадавхад тавих шаардлага MIS ISO 15189 2015 стандартын 4.9.4.10.4.14.8.5.4.4.5.4 .5	Анхдагч дээж цуглуулах хадгалах тээвэрлэх журамтай түүнийг мөрддөг шинжилгээний өмнөх шинжилгээний үед шинжилгээний дараа гарсан зл тохирлыг тодорхойлж шалтгааныг арилгах залруулах арга хэмжээ авдаг, эмч өвчтөн лабораторийн ажилтан бусад талуудаас хүлээн авсан санал гомдол хүсэлтийг шийдвэрлэх журамтай.
3	ЭМТХ-ийн 20.2 Эрүүл мэндийн лабораторийн чанар ба чадавхад тавих шаардлага MIS ISO 15189, 2015 4,8	Эмч өвчтөн лабораторийн ажилтан бусад талуудаас хүлээн авсан гомдол хүсэлтийг шийдвэрлэх журамтай
4	ЭМТХ-ийн 20,2,1 Эрүүл мэндийн лабораторийн чанар ба чадавхад тавих шаардлага MIS ISO 15189 2015 стандарт	Чанарын дотоод хяналтыг долоо хоногт 2 удаа хийж ажиллаж байна. Чанарын гадаад хяналтыг жилд 1 удаа лавлагаа лабораториор хийлгэж үл тохирол эсвэл болзошгүй үл тохирол илэрсэн байвал нэн даруй залруулах арга хэмжээ авна.

.....ОоО.....

Эрүүл мэндийн төвийн даргын 2025 оны 4 дүгээр сарын 25 -ны
өдрийн А/18 дүгээр тушаалын гуравдугаар хавсралт

ЛАБОРАТОРИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Зорилго

1. Үйлчлүүлэгчийг эрүүл мэндийн тусламж үйлчилгээг авах үед хүлээгдэл чирэгдэлгүйгээр үзлэг шинжилгээнд хамруулж өвчтөнийг оношлуулж хугацаа алдалгүй үнэн зөв, тусламж үйлчилгээ үзүүлэхэд оршино.

Хоёр: Сумд заавал хийгдэх шаардлагатай шинжилгээнүүдийг хийх дараалал

- 2.1. Цусны ерөнхий шинжилгээ
- 2.2. Шээсний ерөнхий шинжилгээ
- 2.3. Биохимийн шинжилгээ
- 2.4. Хурдавчилсан аргаар элэгний В,С вирусийн шинжилгээ
- 2.5. Хурдавчилсан аргаар ХДХВ, тэмбүү
- 2.6. Шимэгч хорхойн өндөг илрүүлэх
- 2.7. Өлөн үеийн сахар тодорхойлох
- 2.8. Цусны АВО бүлэг, резус фактар тодорхойлох
- 2.9. Хеликобактер тодорхойлох
- 2.10 Сүрьеэгийн үүсгэгч илрүүлэх шинжилгээ

Гурав. Лабораторийн аюулгүй ажиллагааг мөрдөж ажиллах заавар

- 3.1 Шинжилгээний гадаад болон дотоод хяналтад жил бүр хамрагдах
- 3.2 Уусмал урвалжийн хадгалалт хугацаа боодлыг тогтмол хянаж ажиллах
- 3.3 Аппарат тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааны цэвэрлэгээ, угаалтыг зааврын дагуу хийдэг байх.
- 3.4 Шинжилгээний бүртгэлүүдийг тус бүрд нь тогтмол хөтөлдөг байх
- 3.5 Багаж тоног төхөөрөмж аппаратын бэлэн байдлыг хангах
- 3.6 Эрүүл мэндийн төвд хэрэглэж байгаа стандартуудыг чанд баримталж ажиллах
- 3.7 Үйлчлүүлэгчдээс авсан цус, шээс, шүлс цэрийг стандартад заасны дагуу устгал хийж, өөрийгөө халдвараас хамгаалах
- 3.8 Ажлын хувцас тогтмол өмссөн байх
- 3.9 Лаборант нь ажлын өдрүүдэд богиносгосон 7 цагаар ажиллах ба шаардлагатай тохиолдолд 24 цагаар ажиллана.

Дөрөв. Лабораторид сорьц хүлээлгэн өгөх

- 4.1 Хэвтэн эмчлүүлэгчийн сорьцыг ээлжийн сувилагч зөөвөрлөнө.
- 4.2 Сорьц хүлээн авсан үйлчлүүлэгчийн овог, нэр регистрийн дугаарыг зөв гаргацтай хөтлөх
- 4.3 Сорьц хүрэлцэхгүй гемолиз болоогүй байх
- 4.4 Сорьцын хоорондоо солихгүй, асраагүй зориулалтын хуруу шилэнд авсан байх
- 4.5 Сорьцыг лабораторийн сорьц хүлээн авах саванд тасаг тасгаар нь хийсэн байх
- 4.6 Сорьцыг амбулаторийн №109 тоот өрөөнд хүлээлгэн өгөх
- 4.7 Тасгуудын шинжилгээг хийсэн даруйд хариуцсан эмчээр баталгаажуулж программд оруулна.

.....ОоО.....

Эрүүл мэндийн төвийн даргын 2025 оны 4 сарын 25 ны
А/10 дугаар тушаалын гуравдугаар хавсралт

ЛАБОРАТОРИЙН УУСМАЛ УРВАЛЖ
ОНОШЛУУР ХҮЛЭЭН АВАХ ЖУРАМ

2025 оны 01 дүгээр сарын 10 өдөр

Бүрд

- Лаборатори нь урвалж оношлуурыг хүлээн авах, хадгалах журмыг гаргаж баримтжуулсан байна.
- Лаборатори нь уусмалын гадна талын, хайрцгийн болон уусмалын бүрэн бүтэн байдлыг шалгаж авна.
- Оношлуурыг хүлээн авах үед гэмтсэн, задарсан буруу хадгалсан, урвалж асгарч гоожсон, норсон их бие гэмтсэн тээвэрлэлтийн явцад ашиглах боломжгүй болсон бол буцаах /худалдан авсан байгууллагад/
- Хэрэглэж болохгүй оношлуур байвал шалтгааныг тодруулах
- Хурдавчилсан оношлуурын шингэлэгч уусмалын хадгалалтын бүрэн бүтэн байдлыг хянах
- Тасалгааны хэмд нарны хурц гэрлээс хол хадгалах
- Лабораторийн уусмалуудыг зориулалтын хөргөгчинд +2 +8 хэмд хадгална.
- Хөргөгчийн хэмийг хянаж өдөр бүр тэмдэглэн баталгаажуулна.
- Оношлуур, урвалжийг хүлээн авахдаа нэхэмжлэлийн хамт авч байх.

.....ОоО.....